



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/368

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын “Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай” 2022 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмнө нь газар өмчилсөн 1 (нэг) иргэний газрын хэмжээг кадастрын зураглалын дагуу өөрчилж, хавсралтад заасны дагуу өмчлүүлсүгэй.

2. Өөрчилсөн газрын хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу газар дээр нь тэмдэгжүүлж, газрын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулан, газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт тус тус даалгасугай.


3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/214 дүгээр захирамжийн тухайн иргэнтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны  
 05 дугаар сарын 19-ны/ний өдрийн  
 А/368 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ, ГЭРЭЭН ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
 ИРГЭДИЙН НЭРС, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/Д	Өмчлөгчийн						Өмнөх газрын хэмжээ /м2/	Өмчлөх газрын хэмжээ /м2/	Өмчилж авсан үнэ	Аймгийн Засаг даргын захирамжид өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хэсэг
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Хаяг	Нэгж талбарын дугаар				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Тайж	Бадарч	Цэцэгээ	ГЭ52020705	Булган сум 1 дүгээр баг Шинэ хороо 16 дугаар гудамж 1606 тоот	6308001877	964	653	2285500	Аймгийн Засаг даргын 2021 оны А/214 дүгээр захирамжаас газрын хэмжээ өөрчлөх

--o00o--